

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 6, түүнээс дээш насны хүн амаас гар утас, интернэт хэрэглээний талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын гар утас, интернэт хэрэглээний талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулан танилцуулж байна.

ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ


Дундговь аймгийн 6, түүнээс дээш насны хүн амын 86.4 хувь нь гар утас хэрэглэдэг болж өмнөх тооллогоос 19.4 пунктээр өсжээ. Сумдын 6, түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Сайнцагаан сумдууд аймгийн дунджаас өндөр байна. Харин Дэлгэрхангай суманд гар утасны хэрэглээ хамгийн доогуур буюу 80.8 хувьтай байна.

ХҮСНЭГТ 9.1 ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМДААР, 2010, 2020 ОН

Сумын нэр	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	58.3	55.1	61.6	86.4	84.4	88.2
Сайнцагаан	64.6	60.2	68.9	88.4	87.0	89.5
Адаацаг	50.3	47.8	53.1	84.1	83.1	85.1
Баянжаргалан	52.5	44.6	62.2	92.6	94.7	90.4
Говь-Угтаал	61.8	59.5	64.3	87.1	84.1	90.1
Гурвансайхан	60.5	57.7	63.4	88.6	89.5	87.7
Дэлгэрхангай	49.8	46.7	52.9	80.8	73.9	86.5
Дэлгэрцогт	52.8	48.0	58.1	87.3	88.1	86.4
Дэрэн	55.7	49.9	61.8	83.1	80.0	86.0
Луус	56.5	55.1	58.2	82.1	72.6	93.6
Өлзийт	54.1	50.6	58.0	83.9	82.1	85.8
Өндөршил	53.7	50.5	57.0	89.4	94.8	84.6
Сайхан-Овоо	49.3	48.1	50.6	85.7	82.8	88.3
Хулд	60.3	61.9	58.6	86.6	85.8	87.4
Цагаандэлгэр	57.0	54.7	59.5	83.5	82.5	84.3
Эрдэнэдалай	55.9	55.2	56.6	85.8	82.5	88.9

6, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 88.2 хувь нь, эрэгтэйчүүдийн 84.4 хувь нь гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс 3.8 пунктээр илүү байна. Насны бүлгийн хувьд 70, түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 20.2 пунктээр бага байна.

ЗУРАГ 9.1 ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМДААР, 2020 ОН




ХҮСНЭГТ 9.2. ГАР УТАС ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	67.0	32.2	34.9	86.4	84.4	88.2
6-9	12.7	5.5	7.2	29.9	51.9	48.1
10-14	48.1	21.1	27.0	75.1	49.0	51.0
15-19	76.1	37.3	38.8	96.8	46.4	53.6
20-24	80.4	41.8	38.5	97.8	45.8	54.2
25-29	81.4	40.0	41.4	96.7	53.6	46.4
30-34	82.5	41.1	41.5	97.9	50.4	49.6
35-39	82.6	39.4	43.1	95.0	45.4	54.6
40-44	78.7	38.4	40.3	96.2	44.1	55.9
45-49	75.3	36.0	39.3	95.2	40.3	59.7
50-54	75.8	34.6	41.2	94.1	45.8	54.2
55-59	73.6	31.9	41.7	94.1	50.4	49.6
60-64	70.0	31.9	38.0	93.9	38.0	62.0
65-69	59.7	27.4	32.3	91.7	42.0	58.0
70+	34.9	15.2	19.6	73.3	39.9	60.1

Гар утас хэрэглэгчдийг байршлаар нь ангилж үзэхэд төв, суурин газрын хүн амын 88.8 хувь нь, хөдөөгийн хүн амын 85.6 хувь нь гар утас хэрэглэгч байна. Хүн амын гар утасны хэрэглээ 2010 оны тооллогоор төв, суурин газарт хөдөөгөөс 21.4 пунктээр илүү байсан бол 2020 онд уг зөрүү багасаж 3.2 пункт болжээ. Энэ нь техник технологийн хөгжлийн хурдацтай


өсөлттэй холбоотой. Өөрөөр хэлбэл орчин үеийн харилцаа холбооны техник, технологи харьцангуй богино хугацаанд өргөн нэвтэрч суурьшил хоорондын ялгаа нь багасаж байна

ЗУРАГ 9.2 ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН



Ажил эрхэлж буй суурин хүн амын 96.3 хувь нь гар утас хэрэглэдэг. Тэдгээрийг хөдөлмөр эрхлэлтийн статусаар харвал аж ахуй нэгж байгууллагын ажил олгогчдын 100 хувь, цалин хөлстэй байнгын ажиллагчдын 99.3 хувь, дагалдан мэргэшиж буй дадлагажигч 100 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн өндөр байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээг хүйсээр харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хэрэглэж байгааг Зураг 9.3-аас харж болно.

ЗУРАГ 9.3. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХУВИАР, 2020 ОН



ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ


Суурин эсвэл хөдөлгөөнт сүлжээгээр интернэтэд холбогдохыг интернэт ашигласан гэж тодорхойлон интернэт хэрэглэгчдийг байнга болон шаардлагатай үед хэрэглэдэг гэж 2 хувааж үзсэн.

6, түүнээс дээш настай хүн амын 57.4 хувь нь интернэт хэрэглэгдэг болж өмнөх тооллогоос 44.2 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 9.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, СУМДААР 2010, 2020 ОН

Сумын нэр	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	11.5	9.6	13.5	57.4	54.0	60.5
Сайнцагаан	19.8	17.2	22.4	61.4	59.0	63.3
Адаацаг	5.4	3.7	7.2	48.1	48.1	48.1
Баянжаргалан	6.5	5.8	7.5	71.1	67.1	75.3
Говь-Угтаал	4.9	4.3	5.6	58.6	56.5	60.6
Гурвансайхан	5.3	4.4	6.2	57.5	54.3	60.5
Дэлгэрхангай	9.2	7.0	11.5	56.2	49.6	61.7
Дэлгэрцогт	6.9	6.6	7.2	54.5	54.8	54.3
Дэрэн	6.8	4.3	9.4	57.8	54.2	61.2
Луус	7.2	4.9	9.9	55.5	46.3	66.7
Өлзийт	6.1	4.9	7.5	63.2	60.4	66.1
Өндөршил	7.6	5.8	9.5	52.8	60.3	46.2
Сайхан-Овоо	5.8	4.6	7.2	53.2	50.0	56.2
Хулд	5.1	3.9	6.3	68.0	64.2	71.7
Цагаандэлгэр	7.4	5.9	9.0	53.8	45.0	60.8
Эрдэнэдалай	8.9	7.8	10.1	46.4	39.9	52.7

ЗУРАГ 9.5. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМДААР 2020 ОН




ХҮСНЭГТ 9.4. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМЫН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сумын нэр	Интернэт хэрэглэдэг хүн амын эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	57.4	54.0	60.5
6-9	11.3	13.9	8.6
10-14	56.6	54.3	58.9
15-19	91.4	87.2	95.2
20-24	93.6	93.3	93.8
25-29	87.0	84.6	89.7
30-34	78.4	73.7	83.2
35-39	64.2	52.8	74.3
40-44	58.9	51.5	64.9
45-49	54.1	46.8	59.4
50-54	40.5	30.8	49.4
55-59	37.1	30.0	44.7
60-64	30.6	32.5	29.4
65-69	14.7	13.3	15.6
70+	2.5	2.4	2.6

6, түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг сумдаар харвал Эрдэнэдалай, Адаацаг, Өндөршил сумдуудад хамгийн бага хувьтай, Баянжаргалан, Хулд, Өлзийт сум зэрэг суурин газрын интернэт хэрэглээ бусад сумдуудтай харьцуулахад өндөр хувьтай байна.

ЗУРАГ 9.5. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН




Интернэт хэрэглэгчдийг байршлаар нь авч үзэхэд хотод амьдарч буй хүн амын 65.0 хувь нь, хөдөөд амьдарч буй хүн амын 54.8 хувь нь интернэт хэрэглэдэг болжээ. 2010 онтой харьцуулбал хөдөөгийн хүн амын интернэтийн хэрэглээ 46.1 пунктээр өссөн байна.

6, түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг хүйсээр харахад эмэгтэйчүүдийн 60.5 хувь, эрэгтэйчүүдийн 54.0 хувь нь хэрэглэдэг байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харахад

60-64 насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их, харин бусад насны бүлгийн хувьд эмэгтэйчүүд их байна

ЗУРАГ 9.6. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



АРАВДУГААР БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн гол үзүүлэлтүүдийг тооллогоор цуглуулан хувь хүний болон өрх, орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдтэй холбосноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хүн ам, орон сууцны тооллогын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

Хүн амын асуулгын эдийн засгийн үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолтыг боловсруулахдаа НҮБ-ын “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж- III”-ийг үндэслэсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон.

Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан ажил эрхэлдэг хүнийг гаргасан.

ЗУРАГ 10.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ


15, түүнээс дээш буюу хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамрууллаа. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог.

Уламжлалт тооллогоор тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажилтай, тооллогын үед ажил эрхлэхгүй байгаа ч ер нь ажил эрхэлдэг хүн амыг болон бүртгэлд суурилсан тооллогоор нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан, гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил эрхэлдэг бүх хүн амыг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг оруулдаг.

ЗУРАГ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН



Хүн ам орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын 65.6 хувь нь ажиллах хүчинд хамрагдаж байгаа нь өмнөх тооллогын дүнгээс 0.2 пунктээр буурсан, харин улсын дунджаас 5.9 пунктээр өндөр байна. (Зураг 10.2)

Ажиллах хүчний оролцооны түвшинг байршил, хүйсээр ангилахад нэлээд ялгаатай байна. Энэ үзүүлэлт хөдөөд хотоос 11.7 пунктээр илүү байгаа нь манай аймгийн онцлог юм. Тооллогоор хөдөөгийн малчин өрхийн 15, түүнээс дээш настай хүмүүсийг үндсэнд нь ажил эрхэлдэг гэж үздэгээс хамаарч, хөдөөгийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр гарахад нөлөөлсөн байх талтай.

Гэхдээ хөдөөгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 2010 оны тооллогын үеийнхээс 2.4 пунктээр буурчээ.


Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 73.8 хувь байгаа нь хотынхоос 14.4 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 10.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүч	65.6	70.5	60.8	56.9	59.4	54.9	68.6	73.8	63.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь	34.4	29.5	39.2	43.1	40.6	45.1	31.4	26.2	36.9

Ажиллах хүчний оролцооны түвшинг Улсын түвшинтэй харьцуулахад 5.9 пунктээр өндөр байна. Ажиллах хүчийг насны бүлгээр авч үзэхэд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдана.

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин дийлэнх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Үүний дотор 20-34 насанд 14.3-16.7 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагчдад эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой. Хүн амын ажиллах хүчний оролцоо 25-44 насанд хамгийн өндөр байгаагийн дотор эрэгтэйчүүдийн хувьд 86.2-89.4 хувьтай бол эмэгтэйчүүдийнх 82.4-89.1 хувьтай байна. Ялангуяа 40-49 насанд хүйсийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшний зөрүү хамгийн бага байгаа нь энэ насанд эдийн засгийн идэвх хамгийн өндөр байгааг гэрчилнэ. Мөн 55-аас дээш насны эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс огцом буурч 18.8-24.4 пунктээр бага байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой. Эдийн засгийн идэвх 35-44 насанд хамгийн өндөр байгаагийн дотор, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийнх 89-өөс дээш хувь байна. Ялангуяа, 35-54 насанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын зөрүү хамгийн бага байгаа нь энэ насанд эдийн засгийн идэвх хамгийн өндөр байгааг гэрчилнэ. Харин 55, түүнээс дээш насанд эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх огцом буурч байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой

ХҮСНЭГТ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүч						Ажиллах хүчнээс гадуурх хүн ам					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүн	хувь*	Хүн	хувь*	Хүн	хувь*	Хүн	хувь*	Хүн	хувь*	Хүн	хувь*
БҮГД	21 364	65.6	1 1402	70.5	9 962	60.8	1 1197	34.4	4 774	29.5	6 423	39.2
15-19	415	11.4	345	18.3	70	4.0	3 230	88.6	1 540	81.7	1 690	96.0
20-24	2 099	54.2	1245	62.3	854	45.6	1 773	45.8	753	37.7	1 020	54.4
25-34	5 892	84.4	3 115	86.2	2 777	82.4	1 090	15.6	497	13.8	593	17.6
35-44	5 831	89.3	2 947	89.4	2 884	89.1	702	10.7	351	10.6	351	10.9
45-54	4 513	86.0	2 253	85.9	2 260	86.2	732	14.0	371	14.1	361	13.8
55-59	1 410	63.8	807	76.6	603	52.2	800	36.2	247	23.4	553	47.8
60+	1 204	29.6	690	40.5	514	21.7	2 870	70.4	1 015	59.5	1 855	78.3

Тайлбар: *Тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь


АЖИЛЛАХ ХҮЧ

Тооллогын өмнөх 7 хоногт ядаж нэг цагаас илүү хугацаагаар цалин орлоготой ажил эрхэлсэн, ажил хайж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулсныг дээр тэмдэглэсэн. Бид ажил эрхлэлтийг богино хугацаагаар тодорхойлж байгаа болохоор НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн ажиллах хүч гэдэг ойлголтыг хэрэглэж байна.

Тооллогоор тухайн тоолуулагч аж ахуйн нэгж, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бол хөдөлмөр эрхэлсэн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн тоолуулагч тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэхийг тодруулан асууж хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн аргачлалын дагуу тодорхойлсон.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан, мөн сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил хайх (бизнес эрхлэх) ямар нэгэн оролдлого хийсэн эсэхийг тодруулсан. Ажил хайж байгаа гэдэгт тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 10.4. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



15, түүнээс дээш насны хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувь 2.7 болж, өнгөрсөн 10 жилийн хугацаанд 7.2 пунктээр буурчээ. Ажилгүй иргэдийн хувь улсын дунджаас 3.2 пунктээр бага, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 5.9 пунктээр бага, ажил эрхлэгчдийн хувь 9.1 пунктээр өндөр байна. Хэдийгээр ажилгүй иргэдийн хувь буурсан ч ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг дараагийн дэд бүлэгт оруулав.

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ

Ажил эрхэлдэг бүх хүмүүсийн эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, ажил эрхлэлтийн байдал гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

ХҮСНЭГТ 10.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Хүйс	2010		2020		2020 / 2010 %
	Хүн	хувь*	Хүн	хувь*	
БҮГД	14770	55.9	20470	62.9	138.6
Эрэгтэй	7819	58.5	10879	67.3	139.1
Эмэгтэй	6951	53.2	9591	58.5	138.0

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Ажил эрхэлдэг хүн амын тоо 2010 оноос хойш 38.6 хувиар өсжээ. Хүйсээр авч үзвэл эрэгтэй, эмэгтэй ижил 38.0-39.1 пунктээр өссөн байна. Харин байршлаар нь авч үзэхэд нэлээд ялгаатай байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 10.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	хүн	хувь*	хүн	хувь*	хүн	хувь*
БҮГД	20470	62.9	4223	50.6	16247	67.1
Эрэгтэй	10879	67.3	1929	51.5	8950	72.0
Эмэгтэй	9591	58.5	2294	49.9	7297	61.9

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Аймгийн хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 62.9 хувь нь ажил эрхэлж байхад уг үзүүлэлт хөдөөд 67.1 хувь байгаа нь аймгийн төвийнхөөс 16.5 пунктээр өндөр байна. Хөдөөгийн хүн ам аймгийн нийт хүн амын 64.5 хувийг эзэлж, хувийн жин жилээс жилд буурч байгаа боловч тэд үндсэндээ мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг нь хөдөөд хөдөлмөр эрхэлдэг хүний хувийн жин аймгийн төвөөс өндөр байх нөхцөлийг бүрдүүлж байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт аймгийн төвийнхөөс 12.0 пунктээр их бол эрэгтэйчүүдийнх 20.5 пунктээр илүү байна.

ХҮСНЭГТ 10.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			2020 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	1 4770	7 819	6 951	2 0470	1 0879	9591	138.6
15-19	493	391	102	400	335	65	81.1
20-24	1834	1 054	780	1 997	1185	812	108.9
25-34	4 700	2 405	2 295	5 596	2 958	2 638	119.1
35-44	4 004	1 976	2 028	5 620	2 818	2 802	140.4
45-54	2 874	1 464	1 410	4 307	2 133	2 174	149.9
55-59	534	334	200	1 355	767	588	253.7
60+	331	195	136	1 195	683	512	361.0

Дээрх хүснэгтээс харахад 15-19 насны ажил эрхэлдэг хүний тоо 2010 оныхоос буурч, харин 20-54 насныхан 8.9-49.9 хувиар өссөн, 55-аас дээш насныхан 2.5-3.6 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 10.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	20470	10879	9591	100.0	100.0	100.0
Менежер	1004	502	502	4.6	5.2	4.6
Мэргэжилтэн	2446	673	1773	6.2	18.5	6.2
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	577	272	305	2.5	3.2	2.5
Контор, үйлчилгээний ажилтан	513	169	344	1.6	3.6	1.6
Худалдаа үйлчилгээний ажилтан	1701	623	1078	5.7	11.2	5.7
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	11533	6780	4753	62.3	49.6	62.3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	779	504	275	4.6	2.9	4.6
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	656	623	33	5.7	0.3	5.7
Энгийн ажил мэргэжил	1040	533	507	4.9	5.3	4.9
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	221	200	21	1.8	0.2	1.8

ХҮСНЭГТ 10.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	2 0470	1 0879	9 591	100.0	53.1	46.9
Менежер _____	1 004	502	502	100.0	50.0	50.0
Мэргэжилтэн	2 446	673	1 773	100.0	27.5	72.5
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	577	272	305	100.0	47.1	52.9
Контор, үйлчилгээний ажилтан	513	169	344	100.0	32.9	67.1
Худалдаа үйлчилгээний ажилтан	1 701	623	1 078	100.0	36.6	63.4
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	11 533	6 780	4 753	100.0	58.8	41.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	779	504	275	100.0	64.7	35.3
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	656	623	33	100.0	95.0	5.0
Энгийн ажил мэргэжил	1 040	533	507	100.0	51.3	48.8
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	221	200	21	100.0	90.5	9.5

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ангилал тус бүрт өөр өөр байгаа нь ажиглагдана. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, энгийн ажил мэргэжил ажээ. Харин суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний алба болон биеийн хүч шаардсан ажил мэргэжлийн 90-с дээш хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Гэтэл мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтан, худалдаа үйлчилгээний ажилтай 10 хүн тутмын 7 нь эмэгтэйчүүд байна.

Ажил эрхэлдэг нийт хүн амын 97.6 хувь нь ямар нэг шатны боловсролтой бөгөөд эрэгтэйчүүдийн 97.0 хувь, эмэгтэйчүүдийн 98.3 хувийг боловсролтой хүмүүс эзэлж байна. Энэ нь өмнөх тооллоготой харьцуулахад нийт боловсролтой хүн амын эзлэх хувь 7 пунктээр, боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь 8.9 пункт, боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь 4.8 пунктээр тус тус өссөн байна. Ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн 14.7 хувь нь дээд боловсролтой байхад эмэгтэйчүүдийн 30.5 хувь нь дээд боловсролтой байгаагаас үзэхэд ажил эрхэлдэг дээд боловсролтой хүмүүсийн дотор эмэгтэйчүүд давамгайлж байна.

Тооллогоор хөдөлмөр эрхэлдэг хүний ажилладаг байгууллага эсвэл эрхэлдэг ажлынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллыг хуулийн этгээд, өөрөөр хэлбэл өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амд үйлчилдэг ашгийн бус төр, олон нийт, шашны зэрэг байгууллагууд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа үйлдвэрлэл үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь ялгаж, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, ажиллах хүчний судалгаа зэрэг олон зорилгоор ашигладаг.

ХҮСНЭГТ 10.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хүн			Дунд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй

Бүгд	20470	10879	9591	100.0	100.0	100.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт	11614	6753	4861	56.7	62.1	50.7
Уул уурхай, олборлолт	344	273	71	1.7	2.5	0.7
Боловсруулах үйлдвэрлэл	638	351	287	3.1	3.2	3.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	240	188	52	1.2	1.7	0.5
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	57	29	28	0.3	0.3	0.3
Барилга	322	277	45	1.6	2.5	0.5
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	1175	527	648	5.7	4.8	6.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	327	276	51	1.6	2.5	0.5
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	259	59	200	1.3	0.5	2.1
Мэдээлэл, холбоо	145	73	72	0.7	0.7	0.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	369	131	238	1.8	1.2	2.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	35	13	22	0.2	0.1	0.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	277	143	134	1.4	1.3	1.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	200	134	66	1.0	1.2	0.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын үйл ажиллагаа	1266	762	504	6.2	7.0	5.3
Боловсрол	1788	410	1378	8.7	3.8	14.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	754	143	611	3.7	1.3	6.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	192	83	109	0.9	0.8	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	447	241	206	2.2	2.2	2.1
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн	11	9	2	0.1	0.1	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	10	4	6	-	-	0.1

Хүн амын 56.7 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр байна. Манай аймгийн хувьд энэ үзүүлэлт улсынхаас 32.5 пунктээр өндөр байгаа нь манай аймгийн эдийн засгийн голлох салбар нь ХАА байгаатай холбоотой. Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, тээвэр агуулахын үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын 75-аас дээш хувь нь эрэгтэйчүүд байхад хүний эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын 75-аас дээш хувь нь эмэгтэйчүүд байна

ХҮСНЭГТ 10.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хүн			Дунд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	20470	10879	9591	100.0	53.1	46.9
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт	11614	6753	4861	100.0	58.1	41.9

Уул уурхай, олборлолт	344	273	71	100.0	79.4	20.6
Боловсруулах үйлдвэрлэл	638	351	287	100.0	55.0	45.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	240	188	52	100.0	78.3	21.7
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	57	29	28	100.0	50.9	49.1
Барилга	322	277	45	100.0	86.0	14.0
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	1175	527	648	100.0	44.9	55.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	327	276	51	100.0	84.4	15.6
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	259	59	200	100.0	22.8	77.2
Мэдээлэл, холбоо	145	73	72	100.0	50.3	49.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	369	131	238	100.0	35.5	64.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	35	13	22	100.0	37.1	62.9
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	277	143	134	100.0	51.6	48.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	200	134	66	100.0	67.0	33.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын үйл ажиллагаа	1266	762	504	100.0	60.2	39.8
Боловсрол	1788	410	1378	100.0	22.9	77.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	754	143	611	100.0	19.0	81.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	192	83	109	100.0	43.2	56.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	447	241	206	100.0	53.9	46.1
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн	11	9	2	100.0	81.8	18.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	10	4	6	100.0	40.0	60.0

Хот, хөдөөгийн хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзэхэд хотын хүн амын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллагчдын хувийн жин өндөр байна. Гэхдээ салбар салбарын ажиллагчдын хувь хөдөөгийнх шиг нэг салбарт хэт төвлөрсөн бус харьцангуй жигд тархжээ. Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллагчдын 70.3 хувийг хөдөөгийн ажиллагчид бүрдүүлж, үүний дараа боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгааллын салбар орж байгаагаас харахад хөдөөд боловсруулах аж үйлдвэрийн салбар муу хөгжсөнийг гэрчилнэ.

ХҮСНЭГТ 10.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хот		Хөдөө	
	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь
Бүгд	4223	100.0	16247	100.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт	185	4.4	11429	70.3

Уул уурхай, олборлолт	106	2.5	238	1.5
Боловсруулах үйлдвэрлэл	247	5.8	391	2.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	155	3.7	85	0.5
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	36	0.9	21	0.1
Барилга	106	2.5	216	1.3
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	586	13.9	589	3.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	159	3.8	168	1.0
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	118	2.8	141	0.9
Мэдээлэл, холбоо	86	2.0	59	0.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	172	4.1	197	1.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	16	0.4	19	0.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	135	3.2	142	0.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	92	2.2	108	0.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын үйл ажиллагаа	655	15.5	611	3.8
Боловсрол	719	17.0	1069	6.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	336	8.0	418	2.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	103	2.4	89	0.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	208	4.9	239	1.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн	1	-	10	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2	-	8	-

Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хэрэглэгддэг дараагийн чухал үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) юм. Тоолуулж байгаа хүний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагадаа гүйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ хэлцэл, тухайн хүний байгууллага, хувь хүнтэй харилцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж өгдөг учраас энэ үзүүлэлт ихээхэн чухал ач холбогдолтой.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 19-р бага хурлаар хөдөлмөр эрхлэлтийн статусыг шинэчлэн баталсан байдаг ба хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогод уг шинэчилсэн хөдөлмөр эрхлэлтийн статусыг ашигласан болно. 2010 болон 2020 оны тооллогын хөдөлмөр эрхлэлтийн хоёр өөр статусыг ашигласан учир дараах байдлаар харьцуулсан болно. Үүнд:

ЗУРАГ 10.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ХУУЧИН СТАТУС

ШИНЭ СТАТУС



Цалин хөлстэй ажиллагч

Цалин хөлстэй байнгын ажиллагч - 1

Цалин хөлстэй түр ажиллагч – 2

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч – 3

Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид - 4



Ажил олгогч

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч- 6

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч - 7



Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч - 8

Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч - 9

Гүйцэтгэх гэрээлэгч - 5



Нөхөрлөл , хоршооны гишүүн

Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч - 8



Мал аж ахуй эрхлэгч

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч- 7

Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч - 9

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн– 10



Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн– 10

ХҮСНЭГТ 10.11. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР 2010, 2020 ОН

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010			
Бүгд	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажиллагч	36.1	32.9	39.7
Ажил олгогч	0.9	1.1	0.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	34.7	55.4	11.5
Нөхөрлөл, хоршооны гишүүн	0.1	0.1	0.1
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	27.7	9.8	47.8
Бусад	0.5	0.7	0.3
2020			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	34.8	29.3	41.2
Цалин хөлстэй түр ажиллагч	2.7	2.5	3.0
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	0.4	0.6	0.2
Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	-	-	-
Гүйцэтгэх гэрээлэгч	0.3	0.4	0.1
ААНБ-ын ажил олгогч	0.2	0.2	0.2
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.2	0.2	0.2
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	0.3	0.2	0.3
Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	56.9	64.5	48.3
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	4.1	2.1	6.5

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2020 онд цалин хөлстэй ажиллагч нийт ажил эрхэлдэг хүн амын 37.9 хувийг эзэлж 2010 оныхоос 1.8 пунктээр өсжээ. Харин ажил олгогчийн эзлэх хувь 0.4 болж өмнөх тооллоготой харьцуулахад 0.5 пунктээр буурсан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувь 57.2 болж 22.5 пунктээр өсжээ. Цалин хөлстэй ажиллагчийн хувийн жин өсөх нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин өссөн нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж байгааг илэрхийлж буй эерэг үзүүлэлт юм (Хүснэгт 10.11)

АЖИЛГҮЙЧҮҮД


Аймгийн хэмжээнд 2020 онд ажилгүй 894 хүн байгаа нь 2010 оныхоос 1729 хүнээр буюу 2.9 дахин буурчээ. Ажилгүйдлийн түвшин 2020 онд 4.2 болж 2010 оныхоос 10.9 пунктээр буурсны дотор хотод 10 пунктээр, хөдөөд 10.1 пунктээр тус тус буурсан байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их байгаатай холбоотойгоор эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин ч мөн өндөр гарчээ. Энэ нь эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдийнхээс бага байгаатай холбоотой.

ХҮСНЭГТ 10.12. АЖИЛГҮЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Хот		Хөдөө	
	Хүн	ажилгүйдлийн түвшин	Хүн	ажилгүйдлийн түвшин	Хүн	ажилгүйдлийн түвшин
2010						
Бүгд	2 623	15.1	1 157	21.1	1 466	12.3
Эрэгтэй	1 509	16.2	653	22.9	856	13.2
Эмэгтэй	1 114	13.8	504	19.1	610	11.2
2020						
Бүгд	894	4.2	525	11.1	369	2.2
Эрэгтэй	523	4.6	294	13.2	229	2.5
Эмэгтэй	371	3.7	231	9.1	140	1.9

Ерөнхийдөө ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд суурин газар шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

ЗУРАГ 10.6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, СУМДААР, 2020 ОН




Ажилгүйдлийн түвшнийг сумдаар харьцуулвал Сайнцагаан сум хамгийн өндөр 8.6 хувь, Баянжаргалан 5.9 хувь, Өндөршил 5.6 хувьтай байгаа нь аймгийн дундаж дүнгээс 1.4-4.4 пунктээр илүү байна. Харин Хулд сум ажилгүйдлийн түвшин 0.7 хувьтай гарсан нь хамгийн бага байна.

ЗУРАГ 10.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, СУМДААР, ХУВЬ, 2020 ОН



ЗУРАГ 10.8. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВЬ, 2020 ОН



Зураг 10.8-с харахад ажилгүйдлийн түвшин 15-19 насанд эмэгтэйчүүдийн хувьд өндөр байгаа нь нас бага, мэргэжилгүй учраас ажлын байрны олдоц хангалтгүй, сурах зорилготой зэрэг олон шалтгаантай холбоотой. Ажилгүйдлийн түвшин 20-24 насанд хүйсийн хувьд хамгийн ойролцоо байна. Харин 35-39 насанд насанд ажилгүйдлийн түвшин хамгийн бага байна.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Ажил эрхэлдэггүй 15, түүнээс дээш насны хүн амаас ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг асуусан. Тухайлбал, сургуульд сурдаг хүн амд 15, түүнээс дээш настай бүх шатны сургуульд өдрөөр суралцагчдыг, хөдөлмөрлөх чадваргүй хүн амд хөдөлмөрлөх насных боловч хөдөлмөрлөх чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүтэн болон хэсэгчлэн алдсан сэргээгдэх боломжгүй хүнийг, гэрийн ажилтайд хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлог зэргээс хамааран ажиллаж чадахгүй байгаа хүнийг тус тус хамааруулав. Тохирох ажил олдохгүй байгаа гэдэг ойлголтод “Ажил хийхийг хүсэж байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны

улмаас тооллогын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй эсвэл тохирох ажлыг хаанаас хайгаа мэдэхгүй байгаа хүмүүсийг” оруулав.

ХҮСНЭГТ 10.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР 2010, 2020 ОН

Ажил эрхлээгүй шалтгаан	2010			2020			2020/ 2010%
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	9 034	4 030	5 004	11 197	4 774	6 423	123.9
Сургуульд сурдаг	2 640	1 225	1 385	4 595	2 066	2 529	174.1
Тэтгэвэрт	3 189	1 157	2 032	3 457	1 050	2 407	108.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	839	465	374	607	321	286	72.3
Гэрийн ажилтай	715	119	596	566	79	487	79.2
Ажиллах сонирхолгүй	31	21	10	56	45	14	180.6
Тохирох ажил олдохгүй байгаа	1 048	643	405	1 240	783	457	123.9
Бусад	572	370	202	673	430	243	117.7

Ажиллах хүчнээс гадуурх 10 хүн тутмын 6 нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 11197 байгаа нь өмнөх тооллогоос 23.9 хувиар өссөн бөгөөд үүний дотор ажиллах сонирхолгүй болон тохирох ажил олдохгүй байгаа хүн ам 20.1 хувиар тус тус өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай хүмүүс 20.8-27.7 пунктээр буурсан бол тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс 23.9 хувиар, бусад шалтгаанаар ажил хийхгүй байгаа хүмүүс 17.7 хувиар тус тус өссөн байна. Гэрийн ажилтайн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа эмэгтэйчүүдийн тоо 2010 оноос 18.3 пунктээр буурсан байна. Гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн тоо өмнөх тооллогоос буурсан хэдий ч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхгүй үндсэн шалтгаанд гэрийн ажил хэвээр байсаар байна.

ХҮСНЭГТ 10.14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Тохирох ажил олдохгүй	Бусад
Бүгд	11 197	4 595	3 457	607	566	1240	59	673
15-19	3 230	3 099	-	17	13	42	4	55
20-24	1 773	1 336	-	30	97	217	0	93
25-34	1 090	150	-	116	210	401	9	204
35-44	702	10	3	134	132	269	13	141
45-54	732	-	119	172	81	219	24	117
55-59	800	-	556	92	25	76	5	46
60+	2 870	-	2 779	46	8	16	4	17

Ажил хийх сонирхолгүй 59 хүн байгаагийн 37 буюу 62.7 хувь нь 35-54 насны хүмүүс байгаа нь цаашид анхааран судлах асуудлын нэг юм.

Тохирох ажил олдохгүй байгаа хүний 97.3 хувь нь боловсролтой, үүний дотор 18.4 хувь нь дээд, 3.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой байна. Энэ нь боловсролын хэрэгцээ, нийлүүлэлт тохирохгүй байгааг харуулна. Гэрийн ажилтай хүмүүсийн 97.0 хувь боловсролтой байгаагийн дотор 19.4 хувь нь дээд боловсролтой, 3.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажээ. Харин ажиллах сонирхолгүй бүх хүний 94.9 хувь боловсролтой, үүний дотор 6.18 хувь нь дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой байна.


Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 34.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам юм. Энэ тоон дээр ажилгүйчүүдийг нэмбэл дээрх насны нийт хүн амын 37.1 хувь нь ажил эрхлэхгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Үүнээс гадна тохирох ажил олдохгүй байгаа, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүйн улмаас хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байгаа хүмүүсийн 18.4 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байгаагийн шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ, 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД

Хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучууд тухайн насны хүн амын хэдэн хувийг эзэлж буйг илэрхийлнэ. Уг үзүүлэлт нь боловсролын системээс гадуур байгаа, сургалтад хамрагдаагүй, хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудыг тодорхойлох бөгөөд залуучуудын ажилгүйдлийн түвшнээс илүүтэй залуучуудын хөдөлмөрийн зах зээлд хамрагдах боломжийг харуулдаг. Хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь нь Тогтвортой хөгжлийн 8-р зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг юм. (ТХЗ-ын 8-р зорилго: Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих)

Монгол Улсын хувьд нийт хүн амын 16.2 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 25.0 хувийг 15-24 насны залуучууд эзэлдэг. Энэ нь залуу насны бүтэцтэй, хүн ам зүйн цонх нээгдсэн манай улс орны хувьд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц нөхцөл бүрэлдсэн, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх боломжтой үе юм.


ЗУРАГ 10.9. 15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020



15-24 насны хүн амын 11.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй залуучууд байна. Энэ нь хөдөлмөрлөх насны залуучуудын 8 хүн тутмын 1 нь хөдөлмөр эрхлээгүй, сургуульд суралцаагүй байгааг илэрхийлж байна. Ялангуяа 15-24 насны эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй хувь 11.6 буюу аймгийн дүнгээс 0.3 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны хүн ам их байгаа хүн ам зүйн таатай

нөхцөл байдал, боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг цаашид анхааран судлах шаардлагатай юм.

ЗУРАГ 10.10. 15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2020 ОН



Хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучуудын 94.1 хувь нь боловсролтой, үүнээс 19.9 хувь нь дээд боловсролтой, 17.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой залуучууд байна. Ялангуяа энэ насны хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй эмэгтэйчүүдийн 27.6 хувь, эрэгтэйчүүдийн 13.1 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.